



ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 1125

Хараат

Малын сэг зэм устгал, халдваргүйтгэлийн
сарын аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.2, 7.3.3 дах хэсэг, аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/222 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Малын өвчний улмаас үхсэн, зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг малын өвчин тархах, байгаль орчин бохирдуулахаас сэргийлж хороо, бууц, худаг уст цэг, бэлчээр, авто замын дагуу болон төв суурин газрын орчмоос цуглуулж, зориулалтын цэгт устгаж халдваргүйтгэх арга хэмжээг 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн 05 дугаар сарын 15-ны дотор сумын хэмжээнд зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2.Урьдчилан сэргийлэх болон зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, байгаль орчны цэвэрлэгээ халдваргүйтгэлийн ажлыг чанар, үр дүнтэй зохион байгуулж, удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийг тасагт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Н.Батгэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  А.ЭРДЭНЭСАЙХАН

